

ТАНИЛЦУУЛГА

“Хүүхдийн эрхийн улсын байцаагчийн ажиллах дүрэм”-ийн төслийн тухай

Улсын Их Хурлаас 2016 оы 02 дугаар сарын 05-ны өдөр батлагдсан Хүүхдийн эрхийн тухай хуульд хүүхдийн эрхийн байцаагчтай байх, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хүүхдийн эрхийн улсын ерөнхий байцаагч байх, хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээр мэргэшиж, сургалтад хамрагдсан ажилтанд улсын байцаагчийн эрх олгохоор хуульчилсан байдаг.

Одоогийн байдлаар улсын хэмжээнд хүүхдийн эрхийн 50 гаруй улсын байцаагч ажиллаж байна. Хүүхдийн эрхийн улсын байцаагч нь Зөрчлийн тухай хуулийн 6.20 дугаар зүйл, 6.28 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 10.23 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчлийг шалган шийдвэрлэхээр Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан.

Улсын хэмжээнд ажиллаж байгаа хүүхдийн эрхийн улсын байцаагчийн тоо цөөхөн, хуулийн тодорхой зохицуулалт байхгүйгээс хүүхдийн эрхийн улсын байцаагчийн чиг үүрэг нь зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа руу түлхүү чиглэж байгаа нь учир дутагдалтай байсан. Хүүхдийн эрхийн улсын байцаагч нь зөрчил шалган шийдвэрлэхээс гадна хяналт шалгалтын арга, хэлбэрээр хүүхдийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хүүхдийн эрхтэй холбоотой зөрчил дутагдлыг илрүүлэх, таслан зогсоох, арилгуулах замаар хүүхдийн эрхийг хангахад чухал үүрэг гүйцэтгэх субъект байх учиртай.

Ийм учраас Улсын Их Хурал 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр Хүүхэд хамгааллын тухай /Шинэчилсэн найруулга/ хууль, уг хуулийг дагалдуулан баталсан Хүүхдийн эрхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар хүүхдийн эрхийн улсын байцаагч нь Төрийн хяналт шалгалтын хуульд заасан бүрэн эрхийг эдлэх, хүүхдийн эрхийн улсын байцаагчийн орон тоо, ажиллах дүрмийг Засгийн газар батлах, хүүхдийн эрхийн улсын байцаагч Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10.8-д заасны дагуу Засгийн газраас баталсан, хүүхдийн эрхийн улсын ерөнхий байцаагчаас олгосон албаны болон хувийн дугаар бүхий үнэмлэх, тэмдэг, зөвлөмж, албан шаардлага, дүгнэлт, торгуулийн хэвлэмэл хуудас хэрэглэх, хүүхдийн эрхийн улсын байцаагчийн эрхийг олгох, цуцлахдаа Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10.5-д заасны дагуу Засгийн газраас баталсан журмын дагуу шийдвэрлэх зэрэг тодорхой зохицуулалтуудыг хуульчилсан.

Хүүхдийн эрх, хамгааллын асуудал нь салбар дундын асуудал тул энэхүү онцлогт тохируулан хүүхдийн эрхийн улсын байцаагчийн дүрмийг Засгийн газраас батлах нь зүйтэй гэж хууль тогтоогч үзэж Хүүхдийн эрхийн тухай хуулийн 20.12-т “Хүүхдийн эрхийн улсын байцаагчийн ажиллах дүрмийг Засгийн газар батална” гэсэн зохицуулалтыг шинээр бий болгосон.

Энэхүү дүрмийн төслийг долоон бүлэгтэйгээр боловсруулсан бөгөөд дараах асуудлуудыг зохицуулахаар тусгалаа:

Нэгдүгээр бүлэгт дүрмийн зорилго, хүүхдийн эрхийн улсын байцаагчийн үйл ажиллагаандаа баримтлах хууль тогтоомж, зарчмыг тусгасан.

Хоёрдугаар бүлэгт хүүхдийн эрхийн хяналтын зорилго, чиглэлийг тусгасан. Цаашид хүүхдийн эрхийн байцаагчийн тоо нэмэгдэж, хяналт шалгалтын үйл ажиллагаа тогтмол хийгдэж эхлэх тул хүүхдийн эрхийн хяналтын чиглэлийг нарийвчлан заах нь зүйтэй гэж үзсэн.

Гуравдугаар бүлэгт улсын байцаагчийн эрх олгох, цуцлах, улсын байцаагчийг сургах асуудлыг зохицуулахаар тусгав. Хүүхдийн эрхийн улсын ерөнхий байцаагч нь улсын ахлах байцаагч, улсын байцаагчийн эрхийг олгох, цуцлах асуудлыг Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10.5-д заасны дагуу Засгийн газраас баталсан журмын дагуу шийдвэрлэнэ.

Дөрөвдүгээр бүлэгт хүүхдийн эрхийн улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч, улсын байцаагчийн эдлэх тодорхой бүрэн эрхүүд, ажил тайлагнах, танилцуулах зохицуулалтыг тусгасан. Хүүхдийн эрхийн ерөнхий байцаагч нь нэг талаас Засгийн газрын гишүүн байх тул улсын ахлах байцаагч, улсын байцаагчийн үйл ажиллагаанд төдийлөн хяналт тавих боломжгүй тул хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дахь салбарын улсын ерөнхий байцаагч нь хүүхдийн эрхийн улсын ахлах байцаагч, улсын байцаагчийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажилладаг байхаар заав. Хүүхдийн эрхийг хангахад салбар, байгууллага бүрийн оролцоо чухал тул хүүхдийн эрхийн зөрчлийн хэрэг бүртгэлт, хэрэгжүүлсэн хяналт шалган дүн, мэдээллийг Хүүхдийн төлөө үндэсний болон орон нутгийн зөвлөл болон иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэх зохицуулалтыг тусгалаа.

Тавдугаар бүлэгт Төрийн хяналт шалгалтын тухай хуульд нийцүүлэн хүүхдийн эрхийн улсын байцаагчаас хяналт шалгалт хийх үйл ажиллагааг тусгав. Ингэхдээ төлөвлөгөөт хяналт шалгалтын тухайд нэг талаас Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн зохицуулалт, нөгөө талаас хүүхдийн эрхийн хяналтын онцлогийг харгалзаж хүүхдийн улсын ерөнхий байцаагч хүүхдийн эрхийн чиглэлээр хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын төлөвлөгөөний төслийг боловсруулж, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5^{1.2}-т заасны дагуу Засгийн газраас батлах салбарын хяналт шалгалтын төлөвлөгөөнд тусган батлуулж, уг төлөвлөгөөнд нийцүүлэн хүүхдийн эрхийн чиглэлээр хийх хяналт шалгалтад хамрагдах объект, хяналт шалгалт хийх нарийвчилсан чиглэлийг батлахаар тусгалаа.

Зургаадугаар бүлэгт Хүүхдийн эрхийн улсын байцаагчаас гаргах шийдвэр, түүнд гомдол гаргах зохицуулалтыг тусгалаа. Ингэхдээ хүүхдийн эрхийн улсын байцаагч нь хяналт шалгалтын бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ Засгийн газраас баталсан "Хяналт шалгалт хийх нийтлэг журам", "Хяналт шалгалтын баримт бичгийн загвар"-ын дагуу хяналт шалгалтын удирдамж, хяналт шалгалтын танилцуулга, шалгалтын тэмдэглэл, хяналтын хуудас, мэдэгдэх хуудас, албан шаардлага, зөвлөмж, дүгнэлт, акт үйлдэхээр заав.

Долоодугаар бүлэгт хүүхдийн эрхийн улсын байцаагчийн бүрэн эрхээ хэрэгжүүлэх баталгаа, төрийн бусад байгууллагатай харилцах, хүүхдийн эрхийн төлөөллийг хэрэгжүүлэх, хариуцлагын асуудлыг тусгалаа.